

ХАМТАРСАН БАГ



ХАМТАРСАН БАГИЙН ГИШҮҮДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭС
УРЬДЧИЛАН СЭРТГИЛЭХ АНЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ



Нэмж засварласан 3 дахь хэвлэлт

© Хүүхдийг ивээх сан (2016, 2019)

© Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк (2023)

Боловсруулсан:

А.Батхишиг (2016, 2019)

Г.Амаржаргал (2023)

Хянан тохиолдуулсан:

Х.Өлзийтунгалаг

Г.Ойнбаяр

Э.Дуламсүрэн (2016, 2019)

Л.Нямгэрэл ГХУСАЗЗАА (2023)

Р.Нарантуяа ХНХЯ (2023)

Гарын авлагын зургийг:

Г.Ганбаяр (2016, 2019, 2023)

Нэмж засварласан 3 дахь хэвлэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк хамтран "Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх" төслийн санхүүжилтээр хэвлэв.

Гарчиг

Өмнөтгөл	4
Товчилсон үгийн жагсаалт	5
Шигтгээ, зураг, хүснэгтийн жагсаалт	7
Нэр томъёоны тайлбар	8
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ОЙЛГОЛТ, ХЭЛБЭР	12
1.1. Ажлын байрны бэлгийн дарамт	16
1.2. Хүн худалдаалах гэмт хэрэг	18
1.3.Бэлгийн хүчирхийлэл	23
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ.....	28
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	39
3.1.Хамтарсан багийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт	39
3.2.Хамтарсан багийн зохион байгуулалт, гишүүдийн чиг үүрэг.....	44
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	48

ӨМНӨТГӨЛ

Хүн бүр амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй бөгөөд гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаалахыг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар бүлэгт хуульчлан баталгаажуулсан.

Түүнчлэн төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна хэмээн тунхаглажээ.

Монгол Улсын Засгийн газар гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг үйлдэж буй хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийг эрт шатанд илрүүлэх, таслах зогсоох, хүчирхийлэлд өртсөн хохирогчийг нөхөн сэргээх цогц үйлчилгээнд хамруулах зорилгоор нилээдгүй хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Энэхүү сургалтын цуврал гарын авлага нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 20 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх Хамтарсан багийн албан хаагч, мэргэжилтнүүдэд зориулсан өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдахаар боловсруулагдсан.

Иймээс Хамтарсан багийн гишүүн та гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, тодорхой тохиолдолд ажиллахдаа энэхүү цуврал гарын авлагыг ашиглаж, үр дүнтэй хамгааллын үйлчилгээ үзүүлнэ гэдэгт найдаж байна.

Цуврал гарын авлагыг бүтээхэд оролцсон нийт судлаач, эрдэмтдэдээ талархал илэрхийлье.

Номын цагаан буян дэлгэрэг.

Л.НЯМГЭРЭЛ

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АА	Архигүй амьдрал бүлэг
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХБ	Азийн хөгжлийн банк
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХТtX	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
НАМС	Нийгмийн ажлын мэдээллийн сан
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
НҮБХАС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан
НҮБХС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан
НҮБХЭХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хороо
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
ОНОТХУ	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
ОУТББ	Олон улсын төрийн бус байгууллага
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУХЭЗБ	Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага
ОУШХБ	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
СЭМ	Сэтгэцийн эрүүл мэнд
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТББ	Төрийн бус байгууллага
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХИС	Хүүхдийг ивээх сан
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХТЭТ	Хүйсийн тэгш эрх төв
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ЭАҮБХУТК	Эмэгтэйчүүдийг алагчлах үйлдлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц
ЭКПАТ	Хүүхдийг бэлгийн мөлжлөг, хүний наймааны бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх олон улсын сүлжээ
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

ШИГТГЭЭ, ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Жендэрт суурилсан хүчирхийллийн шинж	13
Зураг 2. Хүч хэрэглэсэн хүчирхийллийн хэлбэр	14
Зураг 3. Жендэрийн ялгаварлан гадуурхалтын хэлбэр	16
Зураг 4. ХХГХ-ийн бүрэлдэхүүн шинж	19
Зураг 5. Бэлгийн хүчирхийллийн хэлбэр	24
Зураг 6. Гэр бүлийн хүчирхийллийн онцлог	35
Зураг 7. Гэр бүлийн хүчирхийллийн тойрог	36
Зураг 8. Хамтарсан багийн бүтэц	39
Зураг 9. Хамтарсан багийн үзүүлэх үйлчилгээ	40
Зураг 10. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төрөл	42
Зураг 11. Хамтарсан багийн үйл ажиллагааны зохион байгуулалт	44
Зураг 12. Хамтарсан багийн гишүүдийн чиг үүрэгт хамаарах хууль тогтоомжийн хамаарал	44
Зураг 13. Хамтарсан багийн гишүүдийн зарим чиг үүрэг	47
Хүснэгт 1. Палермо протокол, Эрүүгийн хуулийн харьцуулалт	20
Хүснэгт 2. Хүн худалдаалах гэмт хэргийн зарим шинж, агуулгын тайлбар	21
Хүснэгт 3. Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйл, Хүчиндэх гэмт хэрэг	24
Хүснэгт 4. Эрүүгийн хуулийн 12.2 дугаар зүйл, Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг	25
Хүснэгт 5. Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйл, Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг	26
Хүснэгт 6. Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйл, Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг	26
Хүснэгт 7. Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйл, Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг	27
Хүснэгт 8. Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хууль дахь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн зохицуулалт	29
Хүснэгт 9. Гэр бүлийн хамаарал бүхий этгээдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой бусад гэмт хэрэг	30
Хүснэгт 10. Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр	32
Хүснэгт 11. Хүүхэд хамгааллын үйлчилгээ	43
Хүснэгт 12. Хамтарсан багийн ахлагч-Засаг даргын чиг үүрэг	45
Хүснэгт 13. Хамтарсан багийн гишүүн-цагдаагийн албан хаагчийн чиг үүрэг	45
Хүснэгт 14. Хамтарсан багийн нарийн бичгийн дарга-Нийгмийн ажилтны чиг үүрэг	46
Хүснэгт 15. Хамтарсан багийн гишүүн-Эрүүл мэндийн ажилтны үүрэг	46

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

1. Бага насны хүүхэд¹ - Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт зааснаар "бага насны хүүхэд" гэж арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг;
2. Биеэ үнэлэх² - төлбөртэйгөөр бусадтай бэлгийн харьцаанд орохыг;
3. Бэлгийн дарамт³ - бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг, эсхүл бэлгийн сэдэлтэй аливаа үйлдлийг давуу эрх, боломж эдлүүлэх болзол болгон тавихыг;
4. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах⁴ - бэлгийн харьцаанд орох, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийх зорилгогүйгээр хохирогчийг тохуурхан доромжлох хэлбэрээр дур хүслээ хангасан үйлдлийг;
5. Бэлгийн мөлжлөг⁵ - хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан үйлдлийг;
6. Бэлгийн халдашгүй байдал⁶ - хүний хүсэл зоригийн эсрэг бэлгийн харьцаанд орох, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлээс ангид байх явдлыг;
7. Бэлгийн харьцаа⁷ - бэлгийн дур хүслээ хангах зорилгоор хийж буй бэлгийн харьцааны шинжтэй үйлдлийг;
8. Бэлгийн харьцаанд орох⁸ - Хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бэлэг эрхтнээ оруулсныг;
9. Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн⁹ - Хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан, хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн эсхүл өөр зүйл оруулсныг;
10. Бэлгийн эрх чөлөө¹⁰ - бэлгийн хамтрагчаа чөлөөтэй сонгох боломжийг;
11. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн¹¹ - гэр бүлийн гишүүд, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаа, гэрлэлт нь цуцлагдсан, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хүн, тэдгээрийн асрамжид байгаа хүмүүсийг;

¹ Эрүүгийн хууль, 10.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2016, №21

² Зөрчлийн тухай хууль, 6.18 дугаар зүйл, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2017, №41

³ Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, 4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2011. №8

⁴ Эрүүгийн хууль, 12.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2016, №21

⁵ Эрүүгийн хууль, 12.3 дугаар зүйл, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2016, №21

⁶ Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй, тусгай анги, УБ.,2020, 59 дэх тал

⁷ Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй, тусгай анги, УБ.,2020, 59 дэх тал

⁸ Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй, тусгай анги, УБ.,2020, 59 дэх тал

⁹ Эрүүгийн хууль, 12.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2016, №21

¹⁰ Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй, тусгай анги, УБ.,2020, 59 дэх тал

¹¹ Эрүүгийн хууль, 10.4 дүгээр зүйлийн тайлбар хэсэг, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2016, №21

12. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч¹² - гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг;
13. Гэр бүлийн хүчирхийлэл¹³ - хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг;
14. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг¹⁴ - хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд хуульд заасан үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэрийг;
15. Жендэр¹⁵ - улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг;
16. Жендэрийн хэвшмэл үзэл¹⁶ - улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлагыг;
17. Жендэрийн шууд бус ялгаварлан гадуурхалт¹⁷ - хүйсэд хамааралгүй аливаа стандарт, хэм хэмжээ, үйлдэл нь хүнийг эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэхийг;
18. Жендэрийн шууд ялгаварлан гадуурхалт¹⁸ - бусдыг хүйсээр ялгаварлаж адил буюу ижил төстэй нөхцөлд эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэсэн, эсхүл хүргэхийг оролдсон үйлдлийг;
19. Жендэрийн эрх тэгш байдал¹⁹ - эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг;
20. Жендэрийн ялгаварлан гадуурхалт²⁰ - улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;
21. Жендэрт суурилсан хүчирхийлэл²¹ - жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг;
22. Кейс менежмент²² - Нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай эрсдэлт нөхцөлд байгаа үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцүүлэн шууд үйлчилгээг хүргэхдээ кейс хариуцсан ажилтан үйлчилгээ дэмжихээс гадна, бусад байгууллага, мэргэжилтний үйлчилгээтэй холбон зуучлах замаар төлөвлөсөн цаг хугацаанд нь тохиромжтой хэлбэрээр,

¹² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №5

¹³ Мөн тэнд

¹⁴ Мөн тэнд

¹⁵ Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, 4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2011. №8

¹⁶ Мөн тэнд

¹⁷ Мөн тэнд

¹⁸ Мөн тэнд

¹⁹ Мөн тэнд

²⁰ Мөн тэнд

²¹ Мөн тэнд

²² Нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, MNS 6949:2021

системтэй шийдвэрлэх мэргэжлийн үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх арга замыг;

23. Мөрдөгч²³ - хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий албан тушаалтныг;
24. Мөрдөн шалгах ажиллагаа²⁴ - хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурорын зөвшөөрлөөр, эсхүл мөрдөгч бие даан явуулах энэ хуульд заасан ажиллагааг;
25. Мөрдөн шалгах нууц ажиллагаа²⁵ - прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулах энэ хуульд заасан ажиллагааг;
26. Нийгмийн ажилтан²⁶ - баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажил, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтныг;
27. Нэг цэгийн үйлчилгээ²⁷ - хохирогчийг эмнэлэг, төрийн, төрийн бус байгууллагад түр байрлуулан эмнэлгийн тусламж болон энэ хуульд заасан бусад үйлчилгээг нэг доор үзүүлэх ажиллагааг;
28. Томилогдсон өмгөөлөгч²⁸ - хуульд заасан тодорхой нөхцөлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийг;
29. Түр хамгаалах байр²⁹ - хохирогчийг тодорхой хугацаагаар байрлуулан энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий стандарт хангасан газрыг;
30. Хамгаалалтын арга хэмжээ³⁰ - гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэнд болон сэтгэл зүйг хамгаалах арга хэмжээг;
31. Хамтран амьдрагч³¹ - гэрлэлтээ бүртгүүлээгүй ч харилцан тохиролцсоны үндсэн дээр гэр бүлийн харилцаа үүсгэн хамтран амьдарч байгаа этгээдийг;
32. Холбон зуучлах үйлчилгээ³² - гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд нь оруулах, нөхөн сэргээхэд туслах зорилгоор холбогдох төрийн, төрийн бус байгууллагад зуучилж, хамтран үйлчилгээ үзүүлэхийг;
33. Хохирогч³³ - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсэн хүнийг;
34. Хүн худалдаалах³⁴ - хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ

²³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 1.4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №3

²⁴ Мөн тэнд

²⁵ Мөн тэнд

²⁶ Хүүхэд хамгааллын тухай хууль, 4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2016. №9

²⁷ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №5

²⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 1.4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №3

²⁹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №5

³⁰ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2013, №30

³¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №5

³² Мөн тэнд

³³ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 3 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2012. №7

³⁴ Мөн тэнд

урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг;

35. Хүний хувийн мэдээлэл³⁵ - хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг;
36. Хүний эмзэг мэдээлэл³⁶ - хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг;
37. Хүчирхийллийн болзошгүй эрсдэл³⁷ - гэр бүлийн хүчирхийлэлд хүргэж болзошгүй, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэх нөхцөл байдлыг;
38. Цахим тодорхойлогч³⁸ - хүнийг цахим орчинд тодорхойлох мэдээллийн системийн нэвтрэх нэр, цахим шуудан, нийгмийн сүлжээ, харилцаа холбооны утастай болон утасгүй технологийн хаяг, бусад төрлийн төхөөрөмж, мэдээллийн систем дэх мэдээллийг;
39. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа³⁹ - гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, түүнд прокурор хяналт тавих, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг;
40. Эрүүл мэндийн мэдээлэл⁴⁰ - хүний бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан тухай мэдээллийг тус тус ойлгоно.

³⁵ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 4.1.11

³⁶ Мөн тэнд

³⁷ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ., 2017. №5

³⁸ Хүний хувийн мэдээлэл хамгаалах хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14.2021 он

³⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 1.4 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ., 2017. №3

⁴⁰ Хүний хувийн мэдээлэл хамгаалах хуулийн 4 дүгээр зүйлийн.4.1.15. 2021 он

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ОЙЛГОЛТ, ХЭЛБЭР

Хүн төрөлхтний аюулгүй байдал, хэвийн аж төрөх ёс, амгалан тайван байдалд аюул, эрсдэл учруулах аливаа үйл явдлаас сэргийлэн хамгаалах явдал нь төр, нийгэм, хувь хүний өмнө тулгамдсан амин чухал асуудлын нэг байсаар ирсэн. Газар хөдлөлт, гал түймэр, үер, ган, зуд зэрэг байгалийн гамшиг, түүнчлэн дайн, зэвсэгт мөргөлдөөн, гэмт халдлага зэрэг хүний хүчин зүйлээс шалтгаалах хүчирхийлэл, ослын зэрэгцээ халдварт өвчин, цар тахал, өлсгөлөн зэрэг байгалийн болон хүний хүчин зүйлийн хосолмол гарвал бүхий аюул нүүрлэж ирснийг түүх гэрчилнэ.

Эдгээр аюул занал нь хүн, нийгэм, төрийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, улс төр, эдийн засгийн тогтвортой байдалд урт болон богино хугацаанд сөргөөр нөлөөлж, нийгмийн сөрөг үзэгдлүүдийг байнга дагуулж байдаг тул тэдгээрээс урьдчилан сэргийлэх, нэгэнт тулгарсан аюулын сөрөг нөлөөг бууруулах, учирсан хохирол, хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, дахин өртөж хохирох явдлаас хамгаалахад чиглэсэн бодлого, хариу арга хэмжээг зөв төлөвлөн хэрэгжүүлэх нь аливаа нэг улс орны төдийгүй олон улсын хамтын хүчин чармайлтыг шаардсан ээдрээ төвөгтэй үйл явц юм. Гэвч урьдчилан сэргийлж, таслан зогсоож, хамгаалах боломжтой хүний хүчин зүйлсээс шалтгаалах аюулаас хүүхэд, өсвөр насны охид, хөвгүүдийг бүрэн хамгаалж чадахгүй байсаар байна.

Хүчирхийлэл нь хүнийг хүсэл зоригийг үл харгалзан өөрийн эрхшээлдээ оруулахад чиглэсэн хүч хэрэглэсэн үйлдэл бөгөөд биеийн хүч ашиглахаас гадна нийгэм-эдийн засгийн болон сэтгэл зүйн дарамт үзүүлэх, албадах, айлган сүрдүүлэх, заналхийлэх зэрэг олон хэлбэрээр илрэх хүний жам ёсны эрхэд халдаж буй гэмт зан үйл юм.

Хүчирхийлэгчийн хувьд хохирогчоос бие физиологийн эсхүл эрх мэдлийн хувьд ямагт давуу байдалтай байдаг. Энэхүү давуу байдал нь зөвхөн биеийн хүчний төдийгүй тодорхой шийдвэр гаргах, санаа бодлоо хэрэгжүүлэх боломж, чадварын тэгш бус байдлын хүлээн зөвшөөрөгдсөн илэрхийлэл гэж үздэг.

Энэ шинжээс нь хамааран хүчирхийллийг дараах хэлбэрүүдэд ангилж болно. Үүнд: бие махбодийн хүч хэрэглэсэн; эдийн засгийн эрх мэдлээ ашигласан; улс төрийн эрх мэдлээ ашигласан; нийгэмд эзлэх байр сууриа ашигласан; жендэрт суурилсан¹ зэргээр ангилна.

Хүчирхийллийн эдгээр хэлбэрүүдээс жендэрт суурилсан хүчирхийлэл (цаашид ЖСХ гэх) нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн байр суурь, үнэлэмж, эрх мэдлийн тэнцвэрт бус байдлаас үүдэлтэй бөгөөд түгээмэл тохиолддог боловч цөөн мэдээлэгддэг² хүний аюулгүй байдалд заналхийлж буй нийгмийн сөрөг үзэгдлийн нэг мөн.

¹ <https://www.unfpa.org/sites/default/files/pub-pdf/>

² United Nations Children's Fund, A Familiar Face: Violence in the lives of children and adolescents, UNICEF, New York, 2017

Зураг 1. Жендэрт суурилсан хүчирхийллийн шинж



НЭГ. ЖЕНДЭРТ СУУРИЛСАН НИЙГЭМД АЮУЛТАЙ СӨРӨГ ЗАН ҮЙЛИЙН ИЛРЭЛ МӨН

Хүчирхийлэл ба жендэрийн ойлголт нь объектив болон субъектив байдлаар харилцан хамааралтай байх бөгөөд аль аль нь тэгш бус, ялгаатай байдлын харьцааг илэрхийлж байдаг нийгмийн үнэлэмж юм.

Жендэр нь эрэгтэй, эмэгтэй хүний дүр төрх, эрх мэдэл, үүрэг хариуцлага, байр суурийн ялгаатай байдлын талаарх нийгмийн хүлээлт, үнэлэмжийг илэрхийлэх хэмжигдэхүүн бөгөөд нийгмийн хувьслыг даган өөрчлөгдөж байдаг. Энэ нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн нийгмийн ялгаатай байдлыг илэрхийлдэг бөгөөд хүйсийн ялгаатай байдалтай адилтган үзэж болохгүй. Хүйс нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгааг илэрхийлэх биологийн болон физиологийн шинжүүдийг илэрхийлэх бөгөөд ямарч үед хувьсан өөрчлөгдөх боломжгүй ялгааг илэрхийлдэг.

Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд зааснаар жендэр гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлага³ юм.

Эмэгтэй, эрэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээндээ энэ тэнцүү үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, адил оролцоотой байхыг жендэрийн тэгш байдал гэнэ. Энэ нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст яг адилхан хандана гэсэн үг биш, харин нөхцөл байдал, боломж, бололцоог нь адил тэгш болгоход анхаарахыг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижил гэсэн үг биш, харин улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан

³ Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэг, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2011, №8

гадуурхалтаас ангид байх нөхцөл бүрдсэнийг ойлгоно.

Жендэрийн тэгш бус байдал нь хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг үүсгэж, хүйсээс нь шалтгаалан боломж, бололцоог нь хязгаарлаж байдаг. Тэгш бус байдал нь орлогын тэгш бус байдал, боловсролын тэгш бус байдал, жендерийн тэгш бус байдал, хөрөнгийн тэгш бус байдал, эрх мэдлийн тэгш бус байдал гээд олон янз байна. Тэгш бус байдлын ойлголт нь ихэвчлэн сайн сайхан байдлыг орлогоор төлөөлүүлэн авч үздэг, "аж байдалд чиглэсэн" уламжлалт үзэл баримтлалыг голчилсон байдаг. Харин боломжид чиглэсэн үзэл баримтлалаар, "аж байдал"-д тухайн хүний төрсөн орчин нөхцөл ихээхэн нөлөөлдөг учраас аж байдлын түвшин гэх мэт бусад хүчин зүйлээс хамаарахгүйгээр хүн бүрд "боломж"-ийг олж авах тэгш эрх өгөгдсөн байх ёстой үздэг.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүст юу хийж болох, болохгүйг тулгаж, хүлээлт, шахалт үүсгэх, ялгаварлан гадуурхах зорилгоор үйлдэгддэг ба шалтгаан нь жендэрийн тэгш бус байдал юм.

ХОЁР. ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН, ХҮЧ ХЭРЭГЛЭХЭЭР ЗАНАЛХИЙЛСЭН, ЭРХ МЭДЭЛ, ДАВУУ БАЙДЛАА АШИГЛАСАН ИДЭВХИТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙНА

ЖСХ-д хэн ч өртөж болох ч ихэвчлэн охид, эмэгтэйчүүдийн эсрэг, эрэгтэйчүүд хүчний давуу байдлаа ашиглан үйлдэж, өөрийн хүрээлэн орчин дахь эрх мэдлийн давуу байдлаараа сүрдүүлэн хүчирхийллээ нуун далдалж, нуугдмал байдалд үргэлжлүүлэх санаа зорилго ямагт агуулж байдаг. Хүчирхийлэл үйлдэгч нь аль ч хүйсийн хүн байж болох хэдий ч энэ төрлийн хэргийн тоо баримтаас харахад ихэнх тохиолдолд эрэгтэйчүүд байна.

Зураг 2. Хүч хэрэглэсэн хүчирхийллийн хэлбэр



Энэ төрлийн хүчирхийлэл нь ихэнхдээ идэвхитэй үйлдлээр илрэх боловч зарим тохиолдолд үл хайхрах, ялгаварлан гадуурхах зэрэг эс үйлдэхүйгээр илэрч болно⁴.

⁴ Эс үйлдэхүй гэдэг нь хууль, гэрээ, дүрэм, журмаар хүлээсэн үүрээ гүйцэтгэхгүй байх, хийх ёстой үйлдэлээ хийхгүй байхыг ойлгоно.

ГУРАВ. ЖСХ ХУВЬ ХҮНД ТӨДИЙГҮЙ НИЙГЭМД ТОДОРХОЙ ХОР УРШИГ УЧРУУЛСАН БАЙНА

ЖСХ-ийн улмаас олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор хамгаалагдсан хүний суурь эрхүүдэд халдаж хор уршиг учруулсан байдаг. Хүний амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, халдашгүй, чөлөөтэй байх, эрүүл мэндээ хамгаалуулах зэрэг хүний эрх, ашиг сонирхолд халдаж, хор уршиг учруулна. Хүчирхийлэлд өртөгч нь ихэнх тохиолдолд охид, эмэгтэйчүүд байх бөгөөд дараах хохирлыг учруулна.

- Хүний амь нас хохирох. Энэ хүчирхийллийн улмаас хохирогч нас барах, амиа хорлох, үр зулбах зэрэг ноцтой хохирол учирч болно.
- Хүний биеийн эрүүл мэндэд хохирол учрах. Хохирогчийн бие, эрхтэнд гэмтэл учрах, шарх үүсэх, тахир дутуу болох, халдварт өвчнөөр өвдөх зэрэг хүнд, хөнгөн хохирол учирна.
- Хүний сэтгэцийн эрүүл мэндэд хохирол учрах. Хүчирхийллийн улмаас санаа сэтгэл цочрон давчдах, гүн цочролд орох, сэтгэцийн хэвийн ажиллагаа алдагдаж түр саатах, согтууруулах болон мансууруулах бодис, хорт зуршилд донтох
- Эдийн хохирол учрах. Хүчирхийллийн улмаас эд хөрөнгө эвдрэх, устгах, зориулалтын дагуу ашиглах боломжгүй болох, ирээдүйд олох орлого тасалдах гэх зэрэг.
- Нийгмийн гадуурхал, доромжлолд өртөх, өөрийгөө тусгаарлах. Энд учирч болох хор уршиг, хохирлын зарим жишээг дурьдсан бөгөөд бүрэн жагсаалт биш. Хохирогч бүр хувь хүн учраас хүчирхийллийн улмаас учирсан хор уршиг, үр дагавар харилцан адилгүй байна.

ЖСХ гэдэг нь бусдыг хянах, эрх мэдлээ мэдрэхийн тулд хэн нэгнийг үгүйсгэх, хязгаарлах, хянах, дарамт шахалт үзүүлэх, заналхийлэх зэрэг ямар ч аргаар үйлдэгдэж болох ба зовиур шаналал, хор хохирол учруулах буюу учруулж болзошгүй санаатай үйлдэл, эс үйлдэхүй юм.

Ялгаварлан гадуурхалт гэж юу вэ?



Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэжээ. Өөрөөр хэлбэл ялгаварлан гадуурхалт бол нийгмийн тодорхой бүлгийн гишүүнийх нь хувьд хүмүүстэй бусад хүмүүсийн адил эрх тэгш хандахгүй байх үйлдлийг хэлнэ⁵.

Зураг 3. Жендэрийн ялгаварлан гадуурхалтын хэлбэр

Жендэрийн ялгаварлан гадуурхалт		
Шууд ялгаварлан гадуурхалт	Шууд бус ялгаварлан гадуурхалт	Тогтолцооны ялгаварлан гадуурхалт

Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийллийн гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг болон ажлын байрны бэлгийн дарамт гэсэн

⁵ Б.Өнөрмаа, Ялгаварлан гадуурхалтын ойлголт, эрх зүйн зохицуулалт, www.mglbar.mn/news/4047

төрлүүд түгээмэл үйлдэгддэг⁶.

Эдгээр хүчирхийллийн хэлбэрүүд нь тусдаа онцлог шинжүүдтэй хэдий ч ЖСХ-ийн хэлбэр болохын хувьд дараах нийтлэг шалтгаантай⁷. Үүнд:

- Жендэрийн тэгш бус байдал;
- Хүний эрхэм чанар, хүний эрхийг хязгаарлах ба үл огоорсон нөхцөл байдал;
- Эрх мэдлийн тэнцвэргүй байдал;
- Ялгаварлан гадуурхал, түүнчлэн нийгэм соёлын бусад хүчин зүйлс багтана.

ЖСХ-ийн олон шалтгаанаас суурь шалтгааныг эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын эрх мэдлийн тэгш бус байдал гэж үздэг. Эрх мэдлийн тэгш бус байдал нь зөрчил, айдас, түгшүүр, хонзогнол, түрэмгийлэл, хүчирхийллийг төрүүлдэг.

Манай улсад жендэрт суурилсан хүчирхийллийн а/ажлын байранд дахь бэлгийн дарамт, б/хүн худалдаалах гэмт хэрэг, в/гэр бүлийн хүчирхийлэл, г/бэлгийн хүчирхийлэл гэсэн төрлүүд зонхилон үйлдэгддэг⁸.

1.1. Ажлын байрны бэлгийн дарамт

Олон улсын түвшинд ажлын байрны бэлгийн дарамттай тэмцэх асуудлыг хурцаар шүүмжилж, хүний эрхийн ноцтой зөрчилд тооцож байгаа бөгөөд 2019 онд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас Хүчирхийлэл, дарамтын тухай 190 дүгээр Конвенцыг батлан гаргасан юм. Тус конвенцод Монгол Улс нэгдэн ороогүй байгаа хэдий ч 2011 онд батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд бэлгийн дарамтын талаарх ойлголт, тодорхойлолтыг тусгасан.

Энэ хуулийн 11 дүгээр зүйлд хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцааг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх талаарх ажил олгогч болон ажилтны эрх, үүргийг хуульчилсан⁹.

Ажлын байрны бэлгийн дарамт нь хүний эрхийг зөрчиж, чимээгүй үйлдэгддэг гэмт хэрэг болохыг дэлхий дахинаа хүлээн зөвшөөрч 130 гаруй орон хууль тогтоомжоо шинэчлэн мөрдсөн байна.

Манай улс 2011 онд баталсан Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуульд анх удаа бэлгийн дарамтын талаарх ойлголтыг тусгасан бөгөөд хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь хэсэгт бэлгийн дарамт гэж бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг, эсхүл бэлгийн сэдэлтэй аливаа үйлдлийг давуу эрх, боломж эдлүүлэх болзол болгон тавихыг хэлнэ гэж заасан.

Мөн Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг зааж өгсөн бөгөөд мөн зүйлийн 39.1.4 дэх хэсэгт "албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн бусдыг аливаа хэлбэрээр хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах, түүнчлэн дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт

⁶ Жендэрийн үндэсний хороо, "Жендэр ба бодлого төлөвлөлт" Модуль сургалт 1-Жендэрийн сургагч багш нарт зориулсан гарын авлага, УБ.,2018, 58 дахь тал

⁷ А.Батхишиг, Хүүхэдтэй зүй бус харьцах явдал, түүний хэлбэрүүд, УБ.,2009

⁸ Жендэр судлал сэтгүүл,УБ.,2016, Тусгай дугаар

⁹ Жендэрийн үндэсний хороо, Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх аргазүйн зөвлөмж, УБ.,2020, 5 дахь тал

үзүүлэх"-ийг хориглосон байна.

Түүнчдэн Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5 дугаар зүйлд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд оролцогч аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох зарчмыг баримтлахаар заасан. дараах суурь зарчмыг баримтална, мөн хуулийн 7 дугаар зүйлд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглохтой дараах асуудлыг зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтан, гуравдагч этгээд бие биедээ үгээр, биеэр, цахимаар болон бусад аливаа хэлбэрээр дараах байдлаар дарамт үзүүлэх, хүчирхийлэл үйлдэхийг хориглоно. Үүнд:

- зодох, цохих зэргээр бусдын эрүүл мэндийн эсрэг хүчирхийлэл үйлдэх, үйлдэхээр заналхийлэх;
- хэл амаар доромжлох, нэр төр, алдар хүндийг гутаах;
- ялгаварлан гадуурхах, бие махбод, сэтгэл зүйн дарамт, бэлгийн дарамт үзүүлэх, хүчирхийлэл үйлдэх, заналхийлэх замаар ажлын байрны тэвчишгүй орчныг үүсгэх.

Мөн ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтан, гуравдагч этгээд бие биедээ хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үгээр, биеэр, цахимаар болон бусад хэлбэрээр илэрхийлэх, бэлгийн харилцаанд орох эсэхээс шалтгаалж ажил, албан тушаал, цалин хөлс зэрэг эдийн засгийн болон бусад байдлаар урамшуулах, эсхүл хохироохоор айлган сүрдүүлэх, тулган шаардах, болзол тавих /quid pro quo/ байдлаар бэлгийн дарамт үзүүлэхийг хориглосон байна.

Түүнчлэн энэ тохиолдолуудад дарамт, хүчирхийлэлд өртөгч нь холбогдох эрх бүхий этгээдэд гомдлоо гарган шийдвэрлүүлэх боломжтой байхаар зохицуулжээ.

Ажлын байрны бэлгийн дарамт нь дараах хэлбэрээр илэрнэ. Үүнд:

- Үйлдлээр илрэх - бэлгийн дур сонирхолоо далдуур илэрхийлсэн зураг, шог зураг, хөдөлгөөн үзүүлэх; бэлгийн агуулга бүхий эд зүйлс, зураг хөрөг, бичлэг үзүүлэх; таагүй санагдуулахаар удаан ширтэх, харах гэх мэт
- Бие махбодид халдах - бие махбодод нь хүрэх, хэт ойртох, наалдах; илэх, үнсэх оролдлого хийх; бэлгийн харилцаанд орохоор завдах, дайрах, хүчиндэх гэх мэт
- Хэл амаар илрэх - бэлгийн агуулгатай асуулт тавих, хошигнол онигоо ярих, дуу авиа гаргах, өмссөн хувцас, биеийн хэлбэр, галбаир, согог, бэлгийн ажил эсвэл бэлгийн чадавхын тухай дүрслэн ярих, бэлгийн санаархал бүхий зурвас илгээх, утсаар ярих, бэлгийн харилцаанд орохыг шаардах, дарамтлах, сүрдүүлэх, мөрдөж мөшгөх, хүсээгүй байхад нь удаа дараа болзоонд урих, гэр, машин, өрөөнд урих, бэлэг өгөх, халамжлах гэх мэт.

УИХ-аас Зөрчлийн тухай хуульд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, Бэлгийн дарамт учруулах үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцож, хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан¹⁰.

¹⁰ Ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Жендэрийн үндэсний хорооны эрхлэн гаргасан АЖЛЫН БАЙРНЫ БЭЛГИЙН ДАРАМТААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ-өөс харна уу
<http://nsug.ub.gov.mn/pdf/belgiin%20daramt%202020.pdf>

Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйл. Бэлгийн дарамт учруулах

1. Бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
2. Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

1.2. Хүн худалдаалах гэмт хэрэг

Хүн худалдаалах гэмт хэрэг нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг бөгөөд сүүлийн жилүүдэд уг гэмт хэргийг хар тамхи, мансууруулах бодис худалдах, тээвэрлэх, мөнгө угаах зэрэг гэмт хэрэгтэй хавсран үйлдэж ихээхэн хэмжээний ашиг орлого олдог хууль бус бизнес болон өргөжиж байгаа нь дэлхий нийтийн анхаарлыг татсан асуудал болоод байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нь ихэвчлэн буурай хөгжилтэй болон хөгжиж байгаа орнуудын орлого багатай, боловсролын түвшин доогуур, эмзэг бүлгийн хүүхэд, эмэгтэйчүүд байдаг бөгөөд тухайн орны эдийн засгийн хөгжил доогуур, иргэдийн эрх зүйн мэдлэг муу байгаа зэрэг нь энэхүү гэмт хэргийн хохирогч болох гол хүчин зүйл болж байна¹¹.

Монгол Улс 2002 онд баталсан Эрүүгийн хуульд анх удаа хүн хулгайлах, хүн худалдах, худалдан авах, хүний цус, эд эрхтэнг хууль бусаар авах гэмт хэргийг хуульчилсан нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдэх эхлэл тавигдсан. Засгийн газраас 2005 онд "Хүн, ялангуяа эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох, энэ чиглэлээр ажилладаг төрийн албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх, уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зөв ойлголт, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх зэрэг олон талт үйл ажиллагаанууд хийгдсэн байна. Улмаар 2008 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд нэгдэн орсон¹². Уг протоколд:

1. Хүн худалдаалах гэмт хэрэг гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл бусдыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ. Хүнийг мөлжих гэдэгт биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг нь авах үйлдлийг ойлгоно.
2. Дээрх аргуудын аль нэгийг ашигласан тохиолдолд хохирогч өөрийг нь дээр дурдсан аргаар мөлжих гэж байгааг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.


¹¹ Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр, УБ.,2017

¹² Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц ба түүний протокол

- Мөлжих зорилгоор хүүхдийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авсан аливаа үйлдэл нь дээр дурдсан аргаар үйлдсэн байхыг шаардахгүйгээр хүн худалдаалах гэмт хэрэгт тооцно гэжээ.

Протоколын уг тодорхойлолтын агуулгыг нарийвчлан задалбал ХХГХ-ийг тодорхойлоход үйлдэл, арга, зорилго гэсэн гурван бүрэлдэхүүн шинжийг авч үздэг.

Зураг 4. ХХГХ-ийн бүрэлдэхүүн шинж



ХХГХ-ийн зорилгын шинж тэмдгүүд нь тухайн хүнд юу тохиолдсон, яагаад тохиолдсон гэдэг дээр төвлөрдөг. Ялангуяа бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөг, албадан хөдөлмөр эсвэл үйлчилгээ үзүүлэх, хүчээр гэрлүүлэх зэргээр хүнийг мөлжиж, ашиг орлого олох сэдэл давамгайлдаг. Ихэнх хохирогчид мөлжлөгт өртсөнийхөө дараа хохирогчоор тогтоогддог бөгөөд мөлжлөг олон хэлбэрээр явагдаж байж болдог.

Монгол Улсад 2000 оны эхээр өрнөсөн эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд боловсруулагдаж, батлагдсан 2002 оны Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд “Хүн худалдах, худалдан авах” гэмт хэргийг шинээр тусгасан (2008 онд Хүн худалдаалах гэж өөрчилсөн). Ийнхүү Эрүүгийн хуульд бие даасан зохицуулалт болж орсон хэдий ч хүн худалдах, худалдан авах гэмт хэрэг үйлдсэн этгээд хүнийг мөлжих зорилгоор худалдаалахдаа элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах гэсэн таван үе шатыг заавал дамжсан байхыг шаардсан нь энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдэж, шалгагдахгүй байх нөхцөлийг бий болгож байжээ.

Улмаар, Монгол Улс 2008 онд Палермогийн протоколд нэгдэн орсонтой холбоотойгоор тухайн үед мөрдөгдөж байсан Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулж, 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд, Хүн худалдаалах гэмт хэргийг хуульчлахдаа уг протоколын тодорхойлолттой үндэсний тодорхойлолтыг зөрчилдөөнгүй болгосон нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүйн нэг том алхам болжээ.

Хүснэгт 1. Палермо протокол, Эрүүгийн хуулийн харьцуулалт

Палермогийн протокол	Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/
“Хүн худалдаалах” гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ.	Хүн худалдаалах гэдэг нь “Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан үйлдлийг хэлнэ.

ХХГХ-ийн шинжийн дагуу дээрх хоёр тодорхойлолтыг нарийвчлан задалбал:	
Зорилго Хүнийг мөлжих зорилгоор	Зорилго Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор
Үйлдлийн арга <ul style="list-style-type: none"> • хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, • хулгайлах, • залилах, • хууран мэхлэх, • эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, • эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах 	Үйлдлийн арга <ul style="list-style-type: none"> • хүч хэрэглэх • хүч хэрэглэхээр заналхийлэх • хулгайлах • хууран мэхлэх • итгэл эвдэх • эрх мэдлээ урвуулах • эмзэг байдлыг нь далимдуулах • хяналтдаа байлгаж байгаа хүнд нь төлбөр төлж, хахуульдах
Үйлдэл хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах	Үйлдэл элсүүлэх; тээвэрлэх; орогнуулах; дамжуулах; хүлээн авах

Монгол Улсын Эрүүгийн хуульд ХХГХ-ийн талаар заасан зохицуулалт нь Палермогийн протоколын тодорхойлолттой агуулгын хувьд бүрэн нийцсэн болох нь харагдаж байна.

Хүснэгт 2. Хүн худалдаалах гэмт хэргийн зарим шинж, агуулгын тайлбар

Ойлголт, нэр томьёо	Тайлбар
Хүч хэрэглэсэн	Гэмт этгээд хохирогчийн бие махбодид халдаж, түүний эсэргүүцлийг няцаасан байхыг ойлгоно. Хохирогчийн бие махбодид халдах үйлдэл нь алгадах, цохих, түлхэх, дарах, хоолойг боох, зэрэг хэлбэртэй байж болно
Хүч хэрэглэхээр заналхийлэх аргаар үйлдсэн	Гэмт этгээд хохирогчийг болон ойр дотны хүнийг ална, эрүүл мэндэд хохирол учруулна, эрх, эрх чөлөөг хязгаарлана зэргээр айлан сүрдүүлсэн байхыг ойлгоно
Хулгайлсан	Хүнийг худалдаалах зорилгоор Эрүүгийн хуулийн 13.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдэл хийхийг ойлгоно
Хууран мэхэлсэн	Үгээр буюу үйлдлээр бодит байдлыг нуун дарагдуулах эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар бусдыг төөөргдүүлснийг ойлгоно. Тухайлбал хохирогчийг гадаад улсад өндөр цалинтай ажилд зуучилна, суралцуулна, тэтгэлэг олгуулна, виз гаргана зэргээр худал амлах хэлбэрээр илэрнэ
Итгэл эвдсэн	Хоёр талын итгэлцэлд үндэслэх бөгөөд хохирогчид ашигтай нөхцөл бий болгоно гэж хуурамч гэрээ бичиг баримт ашиглан итгүүлэх, дараа нь итгэлийг нь хөсөрдүүлснийг ойлгоно
Эрх мэдлээ урвуулан ашигласан	Албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж үйлдсэнийг ойлгоно
Хохирогчийн эмзэг байдлыг далимдуулсан	Хохирогчийн эдийн засаг, эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин түүнчлэн, амьдрал ахуйн бусад хүнд байдал зэргийг ашигласан байхыг ойлгоно
Хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулсан	Хохирогчийг бүх хэлбэрээр хяналтдаа байлгаж буй этгээд өөртөө эдийн болон эдийн бус ашигтай байдлыг бий болгох болзолтойгоор бусдад хүнийг шилжүүлж буй үйлдлийг ойлгоно
Элсүүлсэн	Хүнийг худалдаалах зорилгоор тухайн болон бусад этгээдийг айлган сүрдүүлэх, тулган шаардах, ятгах замаар гэмт ажиллагааны оролцогч болгох, хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй болон эрхшээлдээ байгаа байдал зэргийг далимдуулан зөвшөөрүүлэх үйлдлийг ойлгоно.

Тээвэрлэсэн	Хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй этгээдийг нэг газраас нөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгслээр ил болон далд хэлбэрээр зөөвөрлөхөөс гадна уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг ойлгоно
Дамжуулсан	Хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд хүнийг гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжуулан хил нэвтрүүлэх, нэг этгээдээс нөгөөд хүнийг шилжүүлэх болон уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хэлнэ
Орогнуулсан	Хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг хүлээн авах этгээдэд шилжих хүртэл түр хугацаагаар өөрийн эсхүл бусдын орон байранд хяналттай болон хяналтгүйгээр нуугдуулан байрлуулахыг ойлгоно
Хүлээн авсан	Худалдаалагдсан хүнийг өөрийн мэдэлд байлгаж, ашиглахаар шилжүүлэн авахыг ойлгоно
Биеийг нь үнэлүүлэх	Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг түүнийг бусадтай төлбөртэйгэр бэлгийн харьцаанд оруулахыг ойлгоно
Бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах	Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг түүнийг садар самуун сурталчилсан кино, дүрс бичлэг, тайчих үзүүлбэр, тоглолт, уралдаан, тэмцээнд оруулахыг ойлгоно
Боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах	Хүн бусад хүнийг хүчээр өөрийн өмч болгон өөрийн дур хүсэл, сонирхлын дагуу ажиллуулахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрхийг хүн дээр хэрэгжүүлж, түүнийг төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлахыг ойлгоно
Эд эрхтнийг авах	Гэмт этгээд өөрийн болоод бусдын бие, эд, эрхтнийг нөхөн сэргээх, аль нэг эрхтнийг орлуулан солих, эсхүл бусдад худалдаалж ашиг олох зорилгоор хүний эд, эрхтнийг авсныг ойлгоно
Албадан хөдөлмөрлүүлэх	Хүний хүсэл зоригийн эсрэг илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, аливаа ажил үйлчилгээг цалин хөлсгүй гүйцэтгүүлэхийг ойлгоно
Хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж	Гэмт этгээд хохирогчийг 18 насанд хүрээгүй эсхүл жирэмсэн гэдгийг түүний гадаад төрх байдал, хоорондын харилцаа, эсхүл бусад эх сурвалжаас лавтай мэдэж байсныг ойлгоно
Хоёр, түүнээс олон хүнийг худалдаалсан	Гэмт этгээд хоёр буюу түүнээс олон хүнийг худалдаалах гэсэн нэгдмэл нэг санаа зорилгоо цаг хугацаанд, эсхүл тодорхой цаг хугацааны дараа хэрэгжүүлсэн байхыг хэлнэ
Монгол улсын хилээр нэвтрүүлсэн	Хүн худалдаалахын тулд Монгол улсын хилийг нууцаар эсхүл хуурамч буюу хууль ёсны баримт бичиг ашиглан илээр нэвтрүүлэхийг ойлгоно
Хүн худалдаалах гэмт хэргийг байнга тогтвортой үйлдсэн	Энэ гэмт хэргийг гурав ба түүнээс дээш удаа үйлдсэн байхыг ойлгоно
Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн	Гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав, түүнээс олон хүний тогтвортой нэгдэл үйлдсэнийг ойлгоно

Түүнчлэн Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол нь баримд бичиг нь ХХГХ-ийн гол объект болох эмэгтэйчүүд, хүүхдийн эрх ашгийг тусгайлан хамгаалсан чиг үүрэгтэй олон улсын эрх зүйн гол баримт бичиг болж байна. Уг протоколд насанд хүрээгүй хүний эсрэг энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхэд гэмт хэргийг ямар аргаар үйлдсэнийг хамаарахгүй гэдгийг онцолсон байдаг.

Хүүхдээр гуйлга гуйлгах, хүүхдийг худалдах, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт үйлдлийг хуульчлахдаа гэмт хэргийн субъектив талын шинж болох гэмт хэргийн зорилгыг тодорхой заагаагүй ч эдгээр үйлдлийг хийлгэх нь гэмт хэрэг үйлдэгдэгчид тодорхой ашигтай байх нь тодорхой харагдаж байгаа юм. Мөн хүүхдэд садар самууныг сурталчлах, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан үйлдэл нь бэлгийн мөлжлөгийн бусад хэлбэрт хамаарна.

1.3.Бэлгийн хүчирхийлэл

Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь хүнийг өөрийн эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг бэлгийн хүчирхийлэл гэнэ¹³. Бэлгийн хүчирхийлэл нь бэлгийн шинжтэй өдөөлт болон үйлдлээр нөгөө хүнийхээ халдашгүй байдлыг эвдэх оролдлого бөгөөд бэлгийн халдлага, хүчин, цус ойртолт, хүчээр биеийг нь үнэлүүлэх, мөн бэлгийн дарамт зэрэг сэтгэл санааны хүчирхийллийн хэлбэрээр ч илэрдэг байна.

Нэр томьёо, тодорхойлолт, журам, бодлого, шүүхийн шийдвэр улс орон бүрд бага зэрэг ялгаатай байж болох ч дараах ерөнхий ойлголтуудыг багтаасан байдаг¹⁴. Үүнд:

- Хүчиндэх гэдэг нь ихэнх улсын хууль тогтоомжид: бие махбодын хүчирхийллээр үйлдэгдсэн бэлгийн харилцаа эсвэл үтрээ, анус руу эр бэлэг эрхтэн, бусад эд зүйлсийг хүчээр оруулсан үйлдлийг хэлнэ хэмээн тусгасан байдаг. Ингэхээр оролдсон үйлдлийг хүчиндэх оролдлого хэмээн үздэг. Хоёроос олон хүчирхийлэгч оролцсон бол бүлэглэн хүчиндсэн гэмт хэрэг гэж үзнэ. Дайн тулааны бүс нутагт бэлгийн хүчирхийллийг дайны зэвсэг болгон ашигладаг бөгөөд ихэвчлэн охид, эмэгтэйчүүд хохирогч нь болдог байна.
- Бэлгийн халдлага гэдэг нь хохирогчийн хүсээгүй нөхцөлд бие махбодод нь хүрэх, бэлгийн сэдэлтэй үйлдэл хийх зэрэг орно. Гол төлөв хүчээр бэлгийн харилцаанд оруулах, бэлгийн гаж хавьталд хүчээр татан оруулах (шулуун гэдсээр болон амаар), хүүхэд хүчирхийлэх, гэр бүлийнхэнтэйгээ бэлгийн харилцаанд орохыг тулгах, хүчирхийлэхийг оролдох зэргээр илэрдэг.
- Бэлгийн дарамт нь хүсээгүй байхад нь тухайн хүний нэр хүндэд халдсан бэлгийн сэдэлтэй үйлдэл гаргах явдал бөгөөд бие махбодоор, үг хэлээр, үгэн бус байдлаар илэрдэг. Үүнээс ажлын байранд тохиолддог хамгийн түгээмэл хоёр төрөл нь:
 - Сүрдүүлэг: ажлын байранд нь ямар нэгэн хөнгөлөлт үзүүлнэ хэмээн амлаж бэлгийн хавьталд орохыг шаардах (ихэвчлэн дарга, ажил олгогч, ээлжийн ахлагч, хамтран ажиллагч, үйлчлүүлэгч г.м.)
 - Дайсагнасан ажлын байр: үг хэлээр, үгэн бус хэлбэрээр, биеийн хэлэмжээр бэлгийн өдөөлт хийж, ажлын байранд дээрэлхэж доромжилсон, дорд үзсэн, хорлонтой нөхцөл байдлыг үүсгэдэг.

Бэлгийн хүчирхийллийн олон хэлбэр бий. Ихэвчлэн жирийн тохиолдлууд мэт эхэлдэг ч ямар нэгэн арга хэмжээ авахгүй өнгөрүүлсээр байвал улам даамжирдаг¹⁵.

¹³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 6 дугаар зүйл

¹⁴ Бусокорн Суриясарн, Нелиэн Хаспелз, Розалинда Терхсост, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага, Модуль 8. Хүчирхийлэл болон мансууруулах бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх гарын авлага, УБ.,2020

¹⁵ Мөн тэнд

Зураг 5. Бэлгийн хүчирхийллийн хэлбэр

Хэл амаар хүчирхийлэх	бэлгийн шинжтэй онигоо ярих, хүний хувийн амьдрал, гадаад төрх, биеийн галбирын талаар хүлээн зөвшөөрч боломгүй яриа өдөөх, хүйсээр нь доромжлох
Дохио зангаагаар дарамтлах	дохих, нүд ирмэх, гараар зангах, хөл, хуруу, гар, уруулаар бэлгийн сэдэлтэй хөдөлгөөн үзүүлэх
Бичгээр дарамтлах	порно зураг үзүүлэх, э-шуудан явуулах, хүсээгүй байхад нь хайрын захиа илгээх
Сэтгэл зүйн дарамт	ичгүүртэй байдалд оруулах, бусдаас тусгаарлах, хүйсээр нь ялгаварлан гадуурхах
Бие махбодын хүчирхийлэл	үнсэх, илэх, чимхэх, шалиг байдлаар биед хүрэх, бэлгийн халдлага хийх, хүчиндэх г.м.
Эдийн засгийн дарамт	ямар нэгэн тусламж үзүүлнэ хэмээн бэлгийн харилцаанд орохыг шаардах, эсэргүүцсэн тохиолдолд ажилгүй болгохоор сүрдүүлэх

Харин манай улс хүний бэлгийн халдашгүй байдлыг Эрүүгийн хуулиар хамгаалсан. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцсон¹⁶. Үүнд:

Хүснэгт 3. Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйл, Хүчиндэх гэмт хэрэг

12.1 дүгээр зүйл. Хүчиндэх		
Үндсэн шинж	Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн	нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

¹⁶ Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2015, №7

Хүндрүүлэх шинж	<ul style="list-style-type: none"> - арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж; - бүлэглэж; - гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж; - хохирогчийг жирэмсэн болгож; - хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдааж; - хоёр, түүнээс олон хүнийг хүчиндэж; - урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн; - харгис хэрцгий аргаар; - бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж; - хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн 	таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
	<ul style="list-style-type: none"> - ураг зулбасан, - арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; - гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн 	найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
	<ul style="list-style-type: none"> - бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн; - энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан 	арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ
<p>Тайлбар:</p> <p>-Хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болно.</p> <p>-Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход дээр дурдсан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.</p> <p>-"Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл" гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно.</p>		

Хүснэгт 4. Эрүүгийн хуулийн 12.2 дугаар зүйл, Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг

12.2 дугаар зүйл. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах		
Үндсэн шинж	Хохирогчийн хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан нь хүчиндэх гэмт хэргийн шинжгүй бол	зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
Хүндрүүлэх шинж	Энэ гэмт хэргийг арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн	нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
	Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн	хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
<p>Тайлбар:</p> <p>-Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн хохирогч нь аль ч хүйсийн хүн байж болно.</p>		

Хүснэгт 5. Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйл, Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг

12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг		
Үндсэн шинж	Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан	нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
Хүндрүүлэх шинж	<ul style="list-style-type: none"> - арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж; - урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн; - хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлж; - хохирогчийг жирэмсэн болгож; - хоёр, түүнээс олон хүний эсрэг; - байнга тогтвортой үйлдсэн 	хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
	<ul style="list-style-type: none"> - ураг зулбасан; - арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон 	таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
	<ul style="list-style-type: none"> - бага насны хүүхдийг албадан оруулж; - зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн 	арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ
<p>Тайлбар: -Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход дээр дурдсан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.</p>		

Хүснэгт 6. Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйл, Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг

12.5 дугаар зүйл. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох		
Үндсэн шинж	Арван найман насанд хүрсэн хүн хохирогчийг арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон	дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
Хүндрүүлэх шинж	<ul style="list-style-type: none"> - хохирогчийг жирэмсэн болгосон; - бэлгийн замын халдварт өвчин халдаасан 	зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

Хүснэгт 7. Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйл, Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг

12.6 дугаар зүйл. Биеэ үнэлэхийг зохион байгуулах		
Үндсэн шинж	Бусдыг биеэ үнэлэхэд зуучилсан, татан оролцуулсан	зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
Хүндрүүлэх шинж	<ul style="list-style-type: none"> - Биеэ үнэлэх газар байгуулсан, - санхүүжүүлсэн, - биеэ үнэлэхийг зохион байгуулсан, - биеэ үнэлэхэд нь тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлээр хангасан 	нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
	<ul style="list-style-type: none"> - Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн 	таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
Тайлбар: -Энэ гэмт хэргийг үйлдэхдээ арван найман насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн бол Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарна.		

Энэ талаар цуврал гарын авлагын 5 дахь хэсэг буюу Цагдаагийн албан хаагчид зориулсан гарын авлагаас дэлгэрүүлэн танилцана уу.

Жендэрт суурилсан хүчирхийллийн нэг хэлбэр болох гэр бүлийн хүчирхийллийн талаар бид дараах бүлэгт дэлгэрүүлэн авч үзнэ.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ

Монгол Улс хүн хоорондын гэрлэх, гэрлэлтээ дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох журам, нөхцлийг тогтоох, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, хүүхэд үрчлэх, гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 1999 оны 06 дугаар сарын 11-ний өдөр анхны Гэр бүлийн тухай хуулийг УИХ-аас баталж, өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Уг хуульд зааснаар “гэрлэлт” гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг; “гэр бүл” гэдэг нь гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хэлнэ¹⁷ гэж тодорхойлжээ.

Нийгэмд гэрлэсэн, урьд нь гэр бүлийн харилцаатай байсан, эсхүл хэзээ нэгэн цагт хамт амьдарч байсан бусад ойр дотны хүмүүсийн зүгээс хүч, эрх мэдлээр далайлгаж, эрхшээлдээ оруулах зорилгоор бие махбод, сэтгэл санаа, бэлгийн харилцаа, эдийн засгийн хэлбэрээр хяналтаа тогтоож, өөрийн хамааралд оруулж буй тэгш бус байдал газар авах хандлага нэгэнт бий болсон. Ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх явдал түгээмэл болсон нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэхийг шаардаж байв.

Энэ ч хүрээнд УИХ-аас 2004 онд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” бие даасан хуулийг баталж, 2007 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим заавар, журмуудыг батлан хэрэгжүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын Засгийн газраас хохирогчдыг хамгаалан байрлуулах, утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээг мэргэшсэн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг байгуулан үйлчилгээ үзүүлж эхэлсэн зэрэг бодлого болон үйл ажиллагааны хүрээнд нааштай алхмууд хийгджээ.

Гэвч гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах, хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлах зарчимд нийцүүлэн шинэтгэх шаардлагатай гэж үзэн УИХ-аас 2016 оны 12 сарын 22-ны өдөр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан, хэрэгжүүлж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход чиглэгдсэн.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар 30 орчим журам, стандартыг холбогдох байгууллага, албан тушаалтнууд баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна¹⁸.

¹⁷ Гэр бүлийн тухай хууль, 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь хэсэг, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ., 1999, №30

¹⁸ <https://genderhub.mn/contents/view/13>

Хуульд зааснаар гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь гэж эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд, тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү, гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд¹⁹ хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүй²⁰-г хэлнэ.

Хүснэгт 8. Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хууль дахь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн зохицуулалт

Хууль	Зүйл хэсэг	Заалт
Зөрчлийн тухай хууль	5.4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг	4.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг: 4.1.зодсон; 4.2.хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; 4.3.бусадтай харилцахыг хязгаарласан; 4.4.хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
Эрүүгийн хууль	11.7 дугаар зүйл Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	1.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга: 1.1.зодсон; 1.2.харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан; 1.3.хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн нэг онцлог шинж нь тухайн зүйлд заасан үйлдлийг гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний эсрэг байнга үйлдсэн тохиолдолд хамаарахаар хуульчилсан болно. Эрүүгийн эрх зүйн онол болон практикт тодорхой үйлдэл, эс үйлдэхүйн давтамжийн шинжийг тодорхойлоход давтан, байнга гэсэн ойлголт хэрэглэдэг бөгөөд байнга гэдэг нь тоон илэрхийллийн хувьд гурав болон түүнээс дээш удаа үйлдэгдсэн байхыг авч үздэг хууль хэрэглээний ойлголт юм²¹.

Иймээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн бие даасан шинж болох гэр бүлийн хамаарал бүхий хүнийг зодсон гэх үйлдэл нь байнга буюу гурав ба түүнээс дээш давтамжтай үйлдэгдсэн байхыг шаардах ба Эрүүгийн хуулиар хамгаалагдсан нэг харилцаа буюу хүний эрүүл мэндийн халдашгүй байдалд хохирол учруулсан нэг үйлдлийг тухайн харилцааны доторх өөр зүйл, хэсгээр давхар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна гэсэн шударга ёсны зарчимд нийцэхгүй тул ГБХ үйлдэж бусдын биед гэмтэл учруулсан нэг үйлдлийг ГБХ үйлдсэн гэмт хэрэг гэж салгаж зүйлчлэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, хохирогчийн эрүүл мэндэд хөнгөн, хүндэвтэр болон хүнд хохирол учруулсан шинжээр Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, хэсгээр тусдаа зүйлчлэгдээгүй, түүнчлэн Зөрчлийн

¹⁹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 3-р зүйл, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ, 2017, №5

²⁰ Мөн тэнд

²¹ Улсын дээд шүүхийн 2019 оны 506 дугаартай тогтоол

тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтад заасны дагуу хариуцлага хүлээгээгүй байна, гэр бүлийн хамааралтай байдлыг нь далимдуулан зодсон гурав ба түүнээс дээш удаагийн бие даасан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан шинжийг хангана гэж тайлбарлажээ.

Гэхдээ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн 3 буюу түүнээс дээш удаа байх байнга үйлдсэн шинжийг хангахгүй ч гэр бүлийн гишүүний бие махбодид гэмтэл учруулсан, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, үл хайхарсан гэх мэт үйлдэл нь өөр бусад гэмт хэргийн шинжийг агуулж байвал эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой юм.

Хүснэгт 9. Гэр бүлийн хамаарал бүхий этгээдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой бусад гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн зүйл хэсэг	Заалт
10.1 дүгээр зүйл. Хүнийг алах	1. Хүнийг алсан бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. Хүнийг: ... 2.8. гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж; ... алсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ.
10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	1. Эд хөрөнгө, албан тушаал, гэр бүлийн хамаарал бүхий харилцаа ²² , бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа хүнийг байнга хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсний улмаас амиа хорлоход гарцаагүй хүргэсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	1. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. Энэ гэмт хэргийг: 2.1. энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн; ... бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	1. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. 2. Энэ гэмт хэргийг: 2.1. энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар; ... бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

²² Тайлбар: -Энэ хуульд заасан "гэр бүлийн хамаарал бүхий харилцаа" гэж гэр бүлийн гишүүд, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаа, гэрлэлт нь цуцлагдсан, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хүн, тэдгээрийн асрамжид байгаа хүмүүсийн хоорондын харилцааг ойлгоно.

11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах	<p>1. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.</p> <p>2. Энэ гэмт хэргийг энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.</p>
12.1 дүгээр зүйл. Хүчиндэх	<p>1. Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2. Энэ гэмт хэргийг:</p> <p>...</p> <p>2.3. гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж;</p> <p>...</p> <p>бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>3. Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>
16.11 дүгээр зүйл. Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх	<p>1. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуулиар хүлээсэн асран хамгаалах үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийн эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учирсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.</p> <p>2. Энэ гэмт хэргийн улмаас хүүхдийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>3. Энэ гэмт хэргийн улмаас хүүхэд нас барсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>

Гэр бүлийн хүчирхийлэл нь дараах хэлбэрүүдтэй байна. Үүнд:

- бие махбодийн хүчирхийлэл
- сэтгэл санааны хүчирхийлэл
- эдийн засгийн хүчирхийлэл
- бэлгийн хүчирхийлэл

Хүснэгт 10. Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр

Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр	Бие махбодийн хүчирхийлэл	хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг
	Сэтгэл санааны хүчирхийлэл	хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгих, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг
	Эдийн засгийн хүчирхийлэл	хүний цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсныг
	Бэлгийн хүчирхийлэл	эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадах

Бие махбодийн хүчирхийлэл

Гэр бүлийн хамаарал бүхий хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд мөн хуулийн үйлчлэлд хамаарах хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг бие махбодын хүчирхийлэл гэнэ²³. Тухайлбал:

- Алгадах, өшиглөх, цохих, зодох, үсдэх гэх мэтээр биед гэмтэл учруулах
- Түлэх, шарх, сорви үүсгэх
- Хутга, мэс, зэвсгийн чанартай зүйл, зэвсэг хэрэглэн сүрдүүлэх, гэмтээх
- Амь насыг нь хохироох гэх мэт²⁴.



Гэр бүлийн гишүүний эсрэг бие махбодийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, хэсэгт зааснаар шийтгэл, эрүүгийн хариуцлага оногдуулна.

Бэлгийн хүчирхийлэл

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт зааснаар “Гэр бүлийн хамаарал бүхий этгээдийг эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг бэлгийн хүчирхийлэл гэнэ²⁵”.



²³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2017, №5, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг

²⁴ Г.Ганбаясгах, Т.Цогзолмаа, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага, УБ.,2018, 12 дахь тал

²⁵ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2017, №5, 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг

Бэлгийн шинжтэй аливаа үйлдэл гэдэгт:

1. Бэлгийн харьцаа-бэлгийн дур хүслээ хангах зорилгоор хийж буй бэлгийн харьцааны шинжтэй үйлдлийг;
2. Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн-Хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан, хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн эсхүл өөр зүйл оруулсныг;

Тодруулбал²⁶:

- Хүслийг үл харгалзан хүч хэрэглэн хурьцал үйлдэх, хүчиндэх
- Хууран мэхлэх, айлган сүрдүүлэх замаар бэлгийн дур хүслээ хангах
- Бэлэг эрхтнийг нь гэмтээх, элдэв аргаар тарчлаах
- Бэлгийн харьцаанд ёс бусаар орох, орохыг шаардах, оруулах гэх мэт.

Хэдийгээр албан ёсоор гэрлэснээр хосуудын дунд бэлгийн харьцааны эрх үүсч байгаа ч бэлгийн хүчирхийлэл үйлдэх эрх үүсэхгүй. Зарим тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчид эхнэр, нөхрөө зодож, үг хэлээр доромжилж, сэтгэл санаагаар дарамталсныхаа дараа бэлгийн харьцаанд албадан оруулдаг. Энэ нь хүчиндэх гэмт хэргийн шинжийг агуулдаг.

Сэтгэл санааны хүчирхийлэл

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт зааснаар "Гэр бүлийн хамаарал бүхий хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгих, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг сэтгэл санааны хүчирхийлэл гэнэ²⁷".



Тодруулбал²⁸:

- Бусдын дэргэд үг хэлээр доромжлох, байнга хараалын үг хэллэг хэрэглэж, бүдүүлэг байдлаар харьцах
- Бусадтай сул талаар нь харьцуулах
- Хийж буй зүйлийг нь байнга хянах, хардах, алхам бүрийг нь мөрдөн мөшгих
- Түүнтэй холбоотой хэн нэгнийг болон зарим зүйлийг хохирооно, сүйтгэнэ гэж айлгах
- Өөрийгөө ална гэж сүрдүүлэх
- Найз нөхөд болон сонирхдог зүйлгүй болгох
- Хэрэв түүнээс салбал бүх юмаа алдана гэж сүрдүүлэх
- Түүнд ирсэн захидлыг замаас нь задлах
- Утсаар ярихад таслах, ярих хүмүүсийн тоо, хугацааг хязгаарлах

²⁶ Г.Ганбаясгах, Т.Цогзолмаа, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага, УБ.,2018, 12 дахь тал

²⁷ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2017, №5, 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг

²⁸ Г.Ганбаясгах, Т.Цогзолмаа, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага, УБ.,2018, 13 дахь тал

- Өөрийн гэр бүлээс гадуур амрагийн явдлаа ярих
- Найз нөхөд, ах дүүсийнхээ хажууд дорд үзэх, түүний тухай худал ярих
- Худалч, хулгайч, сэтгэцийн өвчтэй, хамгийн муу хүн гэдэгт итгүүлэх
- Хүсэл мөрөөдөл, үзэл бодлыг нь үл ойшоох
- Гутаах, доромжлох, хараах, загнах, буруутгах
- Нэр хоч өгөх, гоочлох, тавлах
- Айлган сүрдүүлэх, зандрах
- Өөртөө болон амьдралд итгэх итгэлгүй болгох
- Заналхийлэх, улмаар амиа хорлоход хүргэх гэх мэт

Эдийн засгийн хүчирхийлэл

Гэр бүлийн хамаарал бүхий хүний цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсныг эдийн засгийн хүчирхийлэл гэнэ²⁹.

Тухайлбал³⁰:

- Мөнгөн орлогод нь хяналт тавих
- Орлогын эх үүсвэргүй болгох, эх үүсвэрээс нь салгах
- Эдийн засгийн эрх мэдэлгүй болгох
- Гэрийн бүх мөнгийг хянаж, цагдах
- Өөрийн гэсэн мөнгөтэй байхыг үл зөвшөөрөх
- Ажил хийх болон боловсрол олоход нь саад хийх
- Зарцуулсан мөнгийг нэг бүрчлэн тооцох
- Мөнгөөр байнга гачигдуулах, мөнгө үрж, хэрэггүй зүйлд зарлаа гэж буруушаах
- Хувцас, ахуйн хэрэглээний зардлаар гачигдуулах гэх мэт

Гэр бүлийн хүчирхийллийн онцлог, үе шат

Гэр бүлийн хүчирхийлэл нь ихэвчлэн эдийн засаг, эрх мэдлийн тэгш бус харьцаатай гэр бүлийн гишүүдийн дунд үйлдэгддэг. Энэ нь хэн нэг хүний ганц нэг удаагийн санамсаргүй үйлдэл бус харин тодорхой зорилготой, урьдаас төлөвлөж, ахин дахин давтан үйлдэж, даамжирдгаараа бусад гэмт хэрэг, зөрчлөөс ялгаатай.

²⁹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2017, №5, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг

³⁰ Г.Ганбаясгах, Т.Цогзолмаа, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага, УБ.,2018, 13 дахь тал

Зураг 6. Гэр бүлийн хүчирхийллийн онцлог

Далд	Гэр бүлийн хүрээнд үйлдэх нь хүчирхийлэгчид хэзээ хүчирхийлэл үйлдэхээ төлөвлөх, бусдад мэдэгдэхгүй байх, хуулийн байгууллагын ажилтнуудын хараанд өртөхгүй байх, өөрийгөө зөвтгөх зэрэг сөрөг талуудыг давуу тал болгон ашигладаг.
Давтагддаг	Энэ үйлдэл нь далд явагддаг тул дахин үйлдэгдэх магадлал хамгийн их. Хүчирхийлэл нь тухайн хүний үзэл хандлагатай шууд холбоотой учир үзэл бодол нь өөрчлөгдөөгүй цагт давтагдсаар л байдаг. Давтамж нь янз бүр байж болно. Зарим тохиолдолд 1-2 жилийн зайтай байх явдал бий.
Даамжирдаг	Гэр бүлийн хүчирхийллийг үл тоох, гэр бүлийн аливаа асуудалд эмэгтэй хүнийг буруутгах хандлага давамгайлдаг учраас эмэгтэйчүүд хүчирхийллийн тухай бусдад мэдээлэхгүй, нууж, улмаар хуулийн байгууллага хүчирхийлэл үйлдэгчид тохирсон ял, шийтгэл оноож чадаагүйгээс гэр бүлийн хүчирхийлэл улам даамжирдаг.

АНУ-ын сэтгэл судлаач Леоноре Волкер 1979 онд Битүү эргүүлэг бүхий гэр бүлийн хүчирхийллийн гурван үе шатыг тодорхойлсон. Энэ гурван үе шатыг зөрчилдөөн хуримтлагдах үе, тэсрэлтийн буюу хүчирхийлэн зодох үе, эвлэрэл буюу бал сарын үе гэж тус тус нэрлэсэн байна.

Манай улсын мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар ч гэр бүлийн хүчирхийлэл нь гурван үе шаттай өрнөж байдаг, ингэхдээ дараагийн хүчирхийлэл нь тэр замналаар давтан үргэлжилж байдаг тойрог маягийн үзэгдэл болохыг судалгаагаар нотолжээ.

Зураг 7. Гэр бүлийн хүчирхийллийн тойрог³¹



31 Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх нь төсөл

ХУРИМТЛАЛЫН ҮЕ

Энэ үед сэтгэл санааны болон бие махбодийн хүчирхийллийн дараах хэлбэрүүд ажиглагдана. Үүнд:

- Харааж зүхэх
- Доромжлох
- Гар далайх
- Гэмтэл, зовиур үүсгэхгүйгээр биед хүрэх

ТЭСРЭЛТИЙН ҮЕ

Энэ үед хүчирхийлэл бодитойгоор үйлдэгдэх бөгөөд дараах хүчирхийллийн хэлбэрүүд дангаар болон аль нэг хэлбэртэйгээ хавсран гүйцэтгэгдэнэ. Үүнд

- бие махбодийн хүчирхийлэл
- сэтгэл санааны хүчирхийлэл
- эдийн засгийн хүчирхийлэл
- бэлгийн хүчирхийлэл

БАЛ САРЫН ҮЕ

Энэ үед хүчирхийлэл үйлдэгч уучлалт гуйн, дахин хэзээ ч ийм үйлдэл хийхгүй хэмээн амлаж, бэлэг авч өгөх зэргээр гуйж гувшдаг. Тэд мөн “архи уугаад ухаанаа алдчихжээ, ажил дээр хүн уур хүргээд, энэ хүүхдүүд” гэх зэрэг тайлбараар өөрийгөө цагаатгадаг.

Энэ үед хохирогч уучилж, түүнд дахин боломж олгох шийдвэр гаргадаг.

Ийнхүү гэр бүлийн хүчирхийллийн тойрогт орж, хүчирхийллийг хүлцэн тэвчих нь дараах үр даварыг бий болгодог. Үүнд:

1. Хувь хүнд үүсэх үр дагавар:

- Хувь хүний эрүүл мэнд,
- Насжилт, хөгжил
- Хөдөлмөрийн бүтээмж буурч, хорт зуршилд автуулах
- Сэтгэл санааны дарамтад оруулах
- Амьдралын идэвхгүй болох

2. Гэр бүлд үүсэх үр дагавар:

- Амьдралын чанар буурах
- Санхүүгийн хямрал, өр зээлд орох
- Орон гэргүйдэх
- Гэр бүл салалт
- Хэн нэг нь ял шийтгэл хүлээх сөрөг үр дагавартай.
- Гэр бүл доторх эмэгтэйчүүд, хүүхдийн амьд явах, аюулгүй байх эрх зөрчигдөх
- Гэр бүлийн гишүүдийн бие, сэтгэл, хувьд эрүүл, боловсролтой, ажилтай, орон байртай, хамт олонтой байх эрх зөрчигдөх

3. Хүүхдэд үүсэх үр дагавар:
 - Хүчирхийллийг харж, сонсож өссөн хүүхэд сэтгэл зүйн хувьд их зовж шаналдаг.
 - Улмаар 1) эрүүл мэнд, 2) сурлагын чанар, 3) хүмүүжилд сөргөөр нөлөөлдөг.
 - Хүүхдийн бие махбод, эрүүл мэнд, сэтгэл санаа ба оюун ухаанд үзүүлэх дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн шууд нөлөөг цаг хугацааны хувьд богино ба урт хугацааны үр дагавар гэж хоёр хуваан авч үздэг.
4. Богино хугацаанд үзүүлэх үр дагаварын нөлөө:
 - Оюун ухаан, танин мэдэхүйн чадвар буурах
 - Бусадтай харилцах харилцаа сөрөг, догшин ширүүн болох
 - Өөртөө итгэлгүй, аймхай болох
 - Нийгэм хамт олны эсрэг хандлагатай болох
 - Сэтгэл санааны хямралтай болох
 - Ууртай, цухалдуу, зан авиртай болох
 - Хэний ч үгийг тоохоо больж, бусдыг хайрлах сэтгэлгүй болох
 - Гэрээсээ дайжих, гадуур тэнэх
5. Урт хугацаанд үзүүлэх үр дагаварын нөлөө:
 - Хүүхэд тамхи, архи болон бусад төрлийн мансууруулах бодис хэрэглэх
 - Хоолны дуршил өөрчлөгдөх ба алдагдах, хэт таргалах
 - Насанд хүрсэн хойноо хэн нэгэнтэй дотно харилцаанд орохоос эмээх
 - Насанд хүрсэн хойноо бэлгийн олон хавьтагчтай болох, биеэ үнэлэх, хүчирхийлэл, дарамтын хохирогч болох
 - Өөрөө хүчирхийлэл үйлдэх, амиа хорлох зэрэг байдлаар илэрдэг
6. Нийгэмд үүсэх үр дагавар:
 - Гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн гишүүдийн хооронд гардаг хувийн шинжтэй харилцаа мэт боловч нийгэмд үзүүлэх нөлөөлөл, хор уршиг өндөр тул нийгмийн асуудал юм.
 - Гэмт хэрэг, зөрчил өсөх, гэр бүл салалт нэмэгдэх, хүүхэд өнчрөх, өрх толгойлсон эмэгтэйчүүд олшрох, ядуурал, хараа хяналтгүй хүүхэд нэмэгдэх зэрэг олон сөрөг үр дагаврыг дагуулдаг.
 - Гэр бүлийн хүчирхийллээс үүдэн эмэгтэйчүүд, хүүхдүүд, гэр бүл, цаашлаад нийгэм, улс үндэстэн ядууралд хүргэх эрсдэлтэй.
 - Хохирогч болсон хүмүүсийн зүгээс гэр бүл, нийгэм, эдийн засаг, улс орны амьдралд оруулах хувь нэмэр, хөдөлмөрийн бүтээмж эрс багасаж, эсэргээрээ цагдаа болон хууль зүйн үйлчилгээ, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ, сэтгэл зүйн болон бусад зөвлөгөө, эрх зүйн туслалцаа, унааны зардал, түр хамгаалах байранд байрлуулах, хохирогчийг чадавхижуулах, үйлчилгээ үзүүлэх гэх мэт шууд зардал нэмэгддэг.

ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


3.1.Хамтарсан багийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт

Гэр бүлийн гишүүдийг гэр бүлийн хүчирхийллээс, хүүхдийг гэр бүлийн болон нийгмийн бусад орчинд хүчирхийлэл, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах, хүчирхийллийг таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, эрх ашиг нь хөндөгдсөн үед нийгмийн ажлын мэргэжлийн цогц үйлчилгээг анхан шатанд үзүүлэх үүрэгтэй анхан шатны нэгж³²-ийг Хамтарсан баг гэнэ.



Өөрөөр хэлбэл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаар хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд хуульд заасан үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэрийг хамтарсан баг гэнэ.

Зураг 8. Хамтарсан багийн бүтэц



Хамтарсан багаас шаардлагатай гэж үзвэл хуульч-өмгөөлөгч, сэтгэл зүйч, орчуулагч-хэлмэрч, хэсгийн ахлагч, олон нийтийн цагдаа, иргэний бүртгэлийн ажилтан, хүний эрх, хүүхдийн эрх, хамгаалал, хүчирхийллийг судлах асуудлаар мэргэшсэн байгууллага, мэргэжилтнүүдийн туслалцааг авч болно.

³² Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалаар балагдсан Хамтарсан багийн ажилллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам

Хамтарсан баг нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн тухай, Хүүхдийн эрхийн тухай хууль болон тэдгээрийг дагаж гарсан, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийг таслан зогсоох, илрүүлэх, хохирогчид туслалцаа дэмжлэг үзүүлэхтэй холбоотой гарсан дүрэм, журмыг дагаж мөрдөж, хэрэгжилийг нь ханган ажиллана.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлд зааснаар хамтарсан баг нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах;
- хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;
- нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх;
- хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;
- хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх;
- хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаархи статистик мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлнэ.

Түүнчлэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар дараах үйлчилгээг хамтарсан багаар үзүүлнэ. Үүнд:

Зураг 9. Хамтарсан багийн үзүүлэх үйлчилгээ



Эмнэлэгийн тусламж, үйлчилгээ

Эмнэлэгийн тусламж, үйлчилгээг хамтарсан багт байгаа эмнэлэгийн мэргэжилтэн үзүүлэх бөгөөд ингэхдээ Эмнэлэгийн тусламж үйлчилгээний тухай хуульд заасан дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- хүний амь насанд аюултай өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, сэхээн амьдруулах, хүндрэхээс сэргийлэхэд чиглэсэн хойшлуулшгүй үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж;
- гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үед эмнэлгийн тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлэгт хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ;
- өвчин эмгэг, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ.

Эмнэлэгийн мэргэжилтнээс хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/394 дүгээр тушаалаар баталсан бөгөөд энэ талаар цуврал гарын авлага-6 буюу Эмч, эмнэлэгийн мэргэжилтэнд зориулсан гарын авлагаас үзнэ үү.

Сэтгэл зүйн зөвлөгөө

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт зааснаар хохирогчид үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээ дараахь хэлбэртэй байна. Үүнд:

- сэтгэл зүйн зөвлөгөө;
- сэтгэл заслын үйлчилгээ.

Хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалаар баталсан.

Энэхүү журамд зааснаар бүх шатны Засаг дарга нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6 дахь хэсэгт заасны дагуу хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх ажлыг зохион байгуулж, хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах зохицуулалтыг тусгажаа.

Хохирогчид үзүүлэх сэтгэл зүйн зөвлөгөө мэдээллийн тухай цэврал гарын авлага-11 буюу Нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх арга зүй гарын авлагаас үзнэ үү.



Нийгмийн хамгааллын үйлчилгээ

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг үйлдэж буй бусад хүчирхийлэлд өртсөн хохирогчид Нийгмийн халамжийн тухай хуульд заасан дараах нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах;
- зөвлөгөө өгөх;
- сэргээн засах үйлчилгээнд хамруулах;
- түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах;
- өдрийн үйлчилгээнд хамруулах;
- гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;
- иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;
- гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;
- нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах.
- гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах.



Дээр дурдсан үйлчилгээг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ гэх бөгөөд үүнд тавигдах шалгуур, журмыг болон Хохирогчид нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Хохирогчид нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой нэмэлт мэдээллийг цуврал гарын авлага-3 буюу Сум, баг, хорооны нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлагаас дэлгэрүүлэн үзнэ үү.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ

Хамтарсан багаас хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхдээ Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан үйлчилгээг үзүүлэх журмыг баримтална.



Зураг 10. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төрөл



Хүснэгт 11. Хүүхэд хамгааллын үйлчилгээ

Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар ирүүлсэн мэдээ, мэдээллийг нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хууль сахиулагч хүлээн авч шалгах, эсхүл шаардлагатай арга хэмжээг хуульд заасны дагуу авна.
Нөхцөл байдлын үнэлгээ хийх	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.
Аюулгүй байдлыг хангах	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээг харгалзан Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаас гадна хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах арга хэмжээг авна.
Дэмжих, холбон зуучлах	Нөхцөл байдлын үнэлгээгээр хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх дүгнэлт гарсан бол иргэний бүртгэл, сэтгэл зүй, хууль зүй, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн болон бусад шаардагдах үйлчилгээнд нийгмийн ажилтан холбон зуучилна.
Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.1-д заасан хамтарсан баг эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар нөхцөл байдлын үнэлгээ хийж, цаашид тухайн хүүхдэд шаардлагатай үйлчилгээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргаж, хуульд заасны дагуу тусламж, үйлчилгээ үзүүлнэ.
Гэр бүлд нь эргэн нэгтгэх	Хуульд заасан үндэслэлээр гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхдийг боломжтой тохиолдол бүрд гэр бүлд нь эргэн нэгтгэнэ.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журмыг үйлчилгээний төрөл тус бүрээр холбогдох асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Хамтарсан багаар хүүхдэд үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар цуврал гарын авлага тус бүрээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Холбон зуучлах үйлчилгээ

Хамтарсан багийн голлох чиг үүрэгтэй оролцогч бол нийгмийн аилтан. Нийгмийн ажилтан нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан нөхцөл байдлын үнэлгээг хийснээр хохирогчийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах боломжтой болно. Өөрөөр хэлбэл нөхцөл байдлын үнэлгээгээр ямар үйлчилгээнд холбон зуучлах нь тодорхой болно.

Нийгмийн ажилтны хийж буй нөхцөл байдлын үнэлгээгээр дараах асуудлыг тодруулахыг зорино. Үүнд:

- гэр бүлийн хүчирхийлэл, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй байдлыг;
- хохирогчид учирсан, эсхүл учирч болзошгүй сөрөг үр дагаврыг;
- хохирогчид үзүүлэх үйлчилгээг.

Хохирогчид үйлчилгээ үзүүлсэн байгууллага, ажилтан үйлчилгээний явц, үр дүнгийн талаар хохирогчийг холбон зуучилсан байгууллагад эргэж мэдээлэх бөгөөд үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, нууцлалыг хангана.

Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/73 дугаартай тушаалаар баталсан бөгөөд холбон зуучлах үйлчилгээний талаар цуврал гарын авлагуудаас дэлгэрүүлэн үзнэ үү.

3.2. ХАМТАРСАН БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГИШҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ

Хамтарсан баг нь сум, баг, хорооны Засаг даргаар ахлуулсан, анхан шатны нэгжид төрийн үйлчилгээг үзүүлж буй мэргэжилтэн, албан хаагчдаас бүрдсэн баг юм.

Зураг 11. Хамтарсан багийн үйл ажиллагааны зохион байгуулалт

Хамтарсан баг нь үйл ажиллагаагаа хагас, бүтэн жилээр төлөвлөн хэрэгжүүлж, тайлангаа дараах байгууллагууд хүргүүлнэ		
Аймгийн Засаг даргын тамгын газар	Аймаг, нийслэлийн ГХУСАЗСЗөвлөл	Орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага

Хамтарсан багийн гишүүд нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомижд заасан тус тусын чиг үүргийг биелүүлж ажиллана³³.

³³ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалаар балагдсан Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх хэсэг

Зураг 12. Хамтарсан багийн гишүүдийн чиг үүрэгт хамаарах хууль тогтоомжийн хамаарал



Хүснэгт 12. Хамтарсан багийн ахлагч-Засаг даргын чиг үүрэг

№	Сум, баг, хорооны Засаг даргын үүрэг
Сум, баг, хорооны Засаг дарга хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор дараахь арга хэмжээг шуурхай авах үүргийг хүлээнэ:	
1	хүчирхийлэл үйлдэгчийг дуудан ирүүлж, шаардлага тавих, сануулга өгөх
2	хохирогчийг эмнэлгийн яаралтай тусламжид холбох, шаардлагатай бол хохирогчийн байгаа орон байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, боломжтой бол хохирогчийг төрөл, садан, ойр дотны хүний түр хамгаалалтад өгөх
3	хохирогчид энэ хууль болон бусад хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлаж, түүнд үзүүлэх үйлчилгээний талаархи мэдээллээр хангах
4	хохирогчийн зөвшөөрснөөр харьяа сум, баг, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэх
5	хүчирхийлэл үйлдэгдсэн тухай хохирогч, хүчирхийлэл үйлдэгч, гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах
6	Дээрх арга хэмжээний талаар цагдаагийн алба хаагчид мэдэгдэж, холбогдох тэмдэглэлийг шилжүүлэх
Сум, баг, хорооны Засаг дарга хохирогч бие махбод, сэтгэл санааны хувьд ноцтой хохирол хүлээсэн, хохирч болзошгүй, эсхүл хүүхэд хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй гэж үзвэл хохирогч зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан харьяа сум, баг, хорооны нийгмийн ажилтанд, эсхүл сургуулийн нийгмийн ажилтанд мэдэгдэнэ.	

Хүснэгт 13. Хамтарсан багийн гишүүн-цагдаагийн албан хаагчийн чиг үүрэг

№	Цагдаагийн байгууллага, албан хаагчийн үүрэг
Цагдаагийн байгууллага нь Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаас гадна гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх талаар дараахь үүргийг хүлээнэ.	
1	хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн талаархи бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ашиглах
2	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн болон үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээллийг хүлээн авч, шаардлагатай тусламж, зөвлөгөө өгөх, холбон зуучлах утас 24 цагаар ажиллуулах

Цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох зорилгоор бусдын орон байранд нэвтрэн орж, дараахь ажиллагааг явуулж болно.

1	хохилогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг шалгах, хуульд заасан журмын дагуу аюулын зэргийн үнэлгээ хийж, түүнийг үндэслэн хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садан, ойр дотны хүний түр хамгаалалтад өгөх
2	хүчирхийлэл үйлдэгчид хүчирхийлэл үйлдэх, согтууруулах ундаа хэрэглэхийг зогсоохыг шаардах
3	аюулын зэрэг өндөртэй, эсхүл хүүхэд хүчирхийлэлд өртсөн бол хохирогч зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан сум, баг, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэх
4	хохилогчид хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлаж, түүнд үзүүлэх үйлчилгээний талаархи мэдээллийг бичгээр өгөх
5	Хохирогчийн эрхийг хангах арга хэмжээ авах
6	шаардлагатай бол хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах
7	галт зэвсэг, хүчирхийлэл үйлдэхэд ашигласан зэвсэг, зэвсгийн чанартай зүйлийг хураан авах

Цагдаагийн алба хаагч шаардлагатай бол гэрч, хохирогч, мэдээлэл өгсөн этгээд, тэдгээрийн гэр бүлийн бусад гишүүн, хохирогчид туслалцаа үзүүлсэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан арга хэмжээг авна.

Хүснэгт 14. Хамтарсан багийн нарийн бичгийн дарга-Нийгмийн ажилтны чиг үүрэг


№ Нийгмийн ажилтны үүрэг	
Сум, баг, дүүрэг, хорооны нийгмийн ажилтан дараахь үүргийг хүлээнэ	
1	хохилогчийг мэдээллээр хангах, сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх
2	гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлыг үнэлэх
3	нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн хохирогчийн хэрэгцээг тодорхойлж, хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах
4	хохилогчийг асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ болон нийгмийн халамжийн тэтгэмжид хамруулах, шаардлагатай бусад үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээг зохион байгуулах
5	хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхэд, гэр бүлийг илрүүлэх судалгааг Засаг дарга, цагдаагийн албан хаагч, эрүүл мэндийн ажилтан болон баг, хорооны ажилтантай хамтран хийх, бүртгэл хөтлөх, үйл ажиллагаандаа ашиглах
6	гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах
7	хохилогчид үзүүлэх хамтарсан багийн үйлчилгээг төлөвлөх, уялдуулан зохицуулах, үйлчилгээний тайлан, мэдээнд үндэслэн дараа жилийн үйлчилгээнд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулах саналыг Засаг даргад гаргах
Сургуулийн нийгмийн ажилтан Боловсролын тухай хуульд зааснаас гадна дараахь үүргийг хүлээнэ	
1	гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх чиглэлээр хамтарсан багтай хамтран ажиллах
2	гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, туслалцаа, дэмжлэгийн талаар эцэг, эх, багш, холбогдох бусад ажилтанд зөвлөгөө өгөх
3	гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурагч, багш, боловсролын байгууллагын бусад ажилтан, эцэг, эхэд мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах
4	Зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох агуулга бүхий бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөр, стандарт, Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих

Хүснэгт 15. Хамтарсан багийн гишүүн-Эрүүл мэндийн ажилтны үүрэг

№ Эрүүл мэндийн ажилтны үүрэг	
Эрүүл мэндийн ажилтан хохирогчийг хамгаалах талаар дараахь үүргийг хүлээнэ	
1	эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогчийг илрүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх, хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж, баримтжуулах
2	хохилогчийг шаардлагатай үйлчилгээний талаархи мэдээллээр хангах

3	эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогчийг илрүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх, хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж, баримтжуулах үүргийг хэрэгжүүлэх ур чадвар эзэмших чиглэлээр сургалтад хамрагдах
4	хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр нийгмийн ажилтантай хамтран ажиллах, мэргэжлийн дүгнэлт гаргах

Зураг 13. Хамтарсан багийн гишүүдийн зарим чиг үүрэг



Хамтарсан баг нь гэр бүлийн хүчирхийлэл, нийгмийн бусад орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зөрчил гарахад хүргэж болох эрсдлийг бууруулах, тохиолдолыг эрт илрүүлэх, хохирлыг багасгах, хамгаалах арга замыг бэхжүүлэх, олон нийт, байгууллага, зорилтот бүлэг, иргэдийн хүчирхийллийг үл тэвчих хандлага, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулах шаардлагатай³⁴. Тухайлбал:

- урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээний хугацаатай хөтөлбөр, төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангах
- хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх
- гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан ургалт, сурталчилгааг зохион байгуулах
- нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд, гэр бүлийн гишүүд хүчирхийлэл, гэмт хэрэг, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, иргэдийн хяналтыг бий болгох
- хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг эцэг эх, асран хамгаалагч, багш, сурган хүмүүжүүлэгч нарт сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохих талуудтай хамтран зохион байгуулах зэрэг байна.

³⁴ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалаар балагдсан Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журмын 4 дүгээр зүйл

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Гэр бүлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,1999, №30
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №5
3. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2013, №30
4. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2011. №8
5. Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2017, №41
6. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2012. №7
7. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2022, №07
8. Хүүхэд хамгааллын тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2016. №9
9. Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2016, №21
10. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ.,2017. №3
11. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц ба түүний протокол
12. Нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, MNS 6949:2021
13. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалаар балагдсан Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам
14. <http://nsug.ub.gov.mn/pdf/belgiin%20daramt%202020.pdf>
15. <https://genderhub.mn/contents/view/13>
16. <https://www.unfpa.org/sites/default/files/pub-pdf/>
17. United Nations Children's Fund, A Familiar Face: Violence in the lives of children and adolescents, UNICEF, New York, 2017
18. А.Батхишиг, Хүүхэдтэй зүй бус харьцах явдал, түүний хэлбэрүүд, УБ.,2009
19. Б.Өнөрмаа, Ялгаварлан гадуурхалтын ойлголт, эрх зүйн зохицуулалт, www.mglbar.mn/news/4047
20. Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй, тусгай анги, УБ.,2020,
21. Бусокорн Суриясарн, Нелиэн Хаспелз, Розалинда Терхсост, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага, Модуль 8. Хүчирхийлэл болон мансууруулах бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх гарын авлага, УБ.,2020
22. Г.Ганбаясгах, Т.Цогзолмаа, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага, УБ.,2018,
23. Жендэр судлал сэтгүүл,УБ.,2016, Тусгай дугаар
24. Жендэрийн үндэсний хороо, "Жендэр ба бодлого төлөвлөлт" Модуль сургалт 1-Жендэрийн сургагч багш нарт зориулсан гарын авлага, УБ.,2018,

25. Жендэрийн үндэсний хороо, Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх аргазүйн зөвлөмж, УБ.,2020,
26. Улсын дээд шүүхийн 2019 оны 506 дугаартай тогтоол

